

Хөрш орнуудын нийтлэг хувь заяаны үзэл баримтлал хийгээд Хятад, Монголын харилцаа

Боржигон Хөгжилт¹

*Дэд профессор
ӨМИС-ийн Монгол Улсыг судлах төв
Хөх, хот, БНХАУ
Цахим хаяг: hugjilt_@126.com*

Хураангуй: Аливаа их гүрний сэргэн мандалт нь түшиг болохуйц хөрш зэргэлдээ дэмжлэг бүсүүдийг шаарддаг. БНХАУ-ын сэргэн мандалт ч мөн бүс нутгийн дэмжлэг, улмаар түүнтэй хөгжлөө хуваалцах, хамтын дэвшилийн үйл явцад сая биеллээ олох учиртай. Хөрш орнуудын нийтлэг хувь заяаны онцлогод хөгжлийн үр дүнгээ хуваалцах, хамтын ажиллагааны аюулгүй байдлаа хангах, иргэд хоорондын эвсэг харилцаа зэргийг хамруулсан байх ёстой. Хөрш орнуудын нийтлэг хувь заяаг байгуулахад Хятадын тал хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхээс гадна хөрш орнуудын ойлголцол, хамтын ажиллагаа, хамтын хүчин чармайлт дутагдаж болшгүй. Монгол, Хятад хөрш орны нийтлэг хувь заяаны буюу шинэлэг харилцааг төлөвшүүлэн буй болгоход улс төрийн итгэлцэл, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн солилцоо, тус үзэл баримтлалын талаарх хамтарсан судалгаа, ажил хэрэгч механизм зэрэг ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

¹ Тус өгүүлэл нь БНХАУ-ын Боловсролын яамны суурь судалгааны баазын томоохон төслийн /дугаар:16JJDGJW008/ дунд шатны бүтээл болно.

Түлхүүр үг: Хөршүүд, нийтлэг хувь заяа, Хятад, Монголын шинэлэг харилцаа, арга зам

Хятад ба түүний хөрш орнуудын харилцаа урт удаан түүхтэй тул өнөөгийн харилцааг нь түүхэн асуудлаас тусгаарлах боломжгүй. Нөгөөтэйгүүр даяаршил, мэдээллийн технологийн шинэчлэл, геополитикийн хувьслыг дагалдан талуудын өнөөгийн харилцаанд олон нарийн төвөгтэй байдал илрэхийн сацуу шинэ шинэ сорилтууд тулгарсаар байна. Түүхэн явцаас харахад Хятад болон түүний хөрш орнуудын харилцаа сайн үед Хятад хөгжин мандаж, муу үед доройтон буурдаг. Хар тамхины дайнаас БНХАУ байгуулагдах хүртэлх 100-аад жил бол Хятадын доройтлын түүх юм. Энэ үед Хятад болон түүний хөрш орнуудын харилцаанд төвөгтэй байдал үүссэн нь Хятадын доройтолд нэг хүчин зүйл болов. БНХАУ байгуулагдсанаас хойш ялангуяа өөрчлөлт нээлттэй бодлогыг хэрэгжүүлсэн 40 гаруй жилд Хятадын хүчин чадал, ялангуяа эдийн засаг ихээр нэмэгдсэн юм. Энэ хэрээр Хятад болон түүний хөршүүдийн харилцаанд өөрчлөлт гарч Хятад нь дийлэнх хөршүүдийнхээ хамгийн том худалдааны түнш, хөрөнгө оруулагч орон болжээ. Мөн хамтын ашиг сонирхолд суурилсан яриа хэлэлцээ, хоёр талт болон олон талт механизм бий болсон нь хөршүүдийн харилцааг бодит агуулгаар баяжуулжээ. Үүнтэй зэрэгцэн Хятадын хөрш орны бодлого нь “сайн хөрш, сайн түнш” улмаар “найрсаг хөрш, баян хөрш, амгалан хөрш” болон өргөжив. Энэ суурин дээр 2013 оны 10 дугаар сард болсон Намын Төв Хорооны хөрш орны бодлогын талаарх анхны хуралд Ши Жинпин дарга хөрш орны бодлогыг газар зүй, байгаль орчин, өөр хоорондын харилцаанаас онцолж, түүний статусыг урьд өмнө байгаагүй түвшинд хүргэв. Эдгээр нь шинэ эринд хөрш орнуудын харилцааг шинэ үзэл баримтлал, арга замаар зохицуулан чиглүүлэх шаардлага буй болсныг харуулж байна.

Нэг. Хөрш орнуудын нийтлэг хувь заяаны үзэл баримтлал дэвшүүлэх болсоны суурь нөхцөл

БНХАУ-ын дарга Ши Жиньпин ХКН-ын XVIII их хурлын дараа хөрш орнуудын нийтлэг хувь заяаны хамруулсан үзэл баримтлалыг өргөн цар хүрээнд онцолж байгаа нь дотоод гадаадын нөхцөл байдалтай холбоотой юм. Үүнд:

Гадаад орчноос үзэхэд, сүүлийн жилүүдэд Хятадын хурдацтай хөгжлийг дагалдан Өрнө дахины зарим их гүрэн нь “тэг нийлбэрийн тоглоом” /zero-sum game/-ын зарчмын дагуу, улс төрийн тогтолцоо, үзэл суртлын ялгааны хүйтэн дайны сэтгэхүйд баригдан, Хятадын хөгжлийн загварыг “ондоо зүйл”, өөрийн хөгжил ба аюулгүй байдалд заналхийлэл учруулж болзошгүй хүчин зүйлээр төсөөлөх болов. Ялангуяа АНУ нь Хятадыг өрсөлдөгч хэмээн тодорхойлж, хязгаарлан тогтоох “олон улсын эвсэл” байгуулах, Хятадын хөрш зэргэлдээ бүсүүдэд будлиан, халуун цэг үүсгэхийг зорих болов. Тухайлбал, АНУ-ын дэвшүүлсэн Азийн дахин тэнцвэржүүлэх хийгээд Энэтхэг-Номхон далайн стратеги, 2018 оноос Хятадтай эхлүүлсэн худалдааны сөргөлдөөн, эдгээрт суурилсан далай тэнгис, арал ольтригийн маргаан нь нийтлэг жишээ юм. Энэ нь Хятадын баримталж байгаа гадаад орчны тогтвортой байдлыг бэхжүүлэх энх тайвнаар зэрэгцэн орших, даяаршлын үр өгөөжийг хүртэн хамтдаа хөгжих хэтийн зорилттой үл нийцэж байна. Хятад нь их гүрний “Тюкидидийн урхи” /Thucydides Trap/-д өртөхгүй, хөрш хоорондын аюулгүй байдлын бэрхшээлээс зайлсхийж, “тэг нийлбэрийн тоглоом”-ыг тэвчин, хөршүүд тэрчлэн дэлхий нийтээр хамтын хөгжилд хүрэхийн төлөө, ийнхүү нийтлэг хувь заяаны үзэл баримтлалыг дэвшүүлж байна хэмээн дүгнэж болох байна.

Дотоод байдлаас үзэхэд, Хятад шинэчлэл нээлттэй бодлого хэрэгжүүлснээс хойш 40 гаруй жилийн эрчимтэй хөгжлөөр эдийн засгийн шинэ хэвийн байдалд орж, бүтэц болон чанарыг сайжруулах, хөгжлийн шинэ хөдөлгүүрт шижих, үйлдвэрлэлийн

арга маягаа өөрчилж, ногоон, тогтвортой хөгжлийг бий болгох, асар их үйлдвэрлэлийн хүчин чадалд зохицуулалт хийн, даяаршлын үйл явцад идэвхитэй оролцох шаардлага урган гарч ирэв. Үүнд юуны өмнө хөрш орнуудтай харилцан туслалцах явдал чухал юм. “Аливаа их гүрний сэргэн мандалт нь түшиг болохуйц хөрш зэргэлдээ дэмжлэг бүсийг шаарддаг”² гэсэнчлэн, сэргэн мандалтын шинэ гараанд буй Хятад улс зайлшгүй бүс нутгийн орнуудтай хөгжлөө хуваалцан хамт дэвшсэнээр л сайн сайхан ирээдүйтэй байж чадна. Мөн энэхүү явцад, Хятадын хөгжлийн үр ашиг эн тэргүүнд хөрш орнуудад нь туссанаар хүн төрөлхтний нийтлэг хувь заяаны байгуулалт чухамдаа хөрш орнуудаас л эхлэх санаа юм. Сүүлийн үед Хятад ба түүний хөрш орнуудын харилцан ашигтай хамтын ажиллагаа гүнзгийрч, эрх ашгийн уялдаа холбоо улам нэмэгдсээр байна. Худалдаа эдийн засгийн хувьд, Хятадын хамгийн том 10 түншийн тал нь, хөрөнгө оруулалтын 70 орчим хувь нь Азийн орнуудад буй. Энэ бол газар зүй, байгаль орчин, уламжлалт харилцаанд суурилсан, хувь заяаны хамтын нэгдлийн материаллаг суурь юм. Нийтлэг хувь заяаг бүтээн байгуулахад тавцан индэр шаардлагатай. 2013 оны 9, 10 дугаар сард Ши Жиньпингийн дэвшүүлсэн “Нэг бүс, нэг зам” санаачилга чухал тавцан болох нь мэдээж. Аюулгүй байдлын хувьд, Хятад нь Азийн бүс нутгийн аюулгүй байдлын механизмын чухал оролцогч бөгөөд тодорхойлогч байж, Хойд Солонгосын цөмийн асуудлаарх зургаан талт уулзалт, Ираны цөмийн хэлэлцээр дэх оролцоо нь бүс нутаг, дэлхий нийтийн аюулгүй байдлыг хамгаалахад хувь нэмрээ оруулж байна. Хятад, Орос болон Төв Азийн орнууд хамтран байгуулсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллага нь “гурван хүчин”-ий эсрэг тэмцэлд дорвитой амжилт гаргаж, өргөжин тэлэхийн хэрээр түүний бүс нутаг дахь нөлөө улам ихэсч байна. “Нэг бүс, нэг зам” санаачлагын хүрээнд “Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор” нь гурван орны бодлогын уялдаа болж, хамтын ашиг сонирхолын давхцалыг нотлохын сацуу эдийн засаг, хүмүүнлэгийн харилцан хамаарал

² 林利民:《中国对外战略:新问题、新任务、新思路》,《现代国际关系》2010年第11期。

бүхий хамтын нэгдэл байгуулах цаг хугацаа ба орон зайн найдвартай боломжийг хангасан байна.

Хоёр. Нийтлэг хувь заяаны үзэл баримтлалын үндсэн агуулга

Ши Жиньпин дарга 2015 оны 3 дугаар сарын 28-нд болсон Боаогийн Азийн форумд хийсэн илтгэлдээ, нийтлэг хувь заяаг дөрвөн талаар тодорхойлжээ. Тэрбээр нийтлэг хувь заяаны нэгдэлд шилжихэд улс орнууд биенээ хүндэтгэх, эрх тэгш байх хэрэгтэй. Хамтран ажиллаж, хамтаар хожиж, хамтын хөгжилд хүрсэн байх хэрэгтэй. Нийтлэг, цогц, хамтарсан, тогтвортой аюулгүй байдлыг буй болгосон байх хэрэгтэй. Эрхбиш адилгүй соёл иргэншлийг уялдуулж, харилцан суралцсан байх хэрэгтэй гэжээ.³ Ийнхүү Ши Жиньпин даргын тодорхойлолт Хятадын гадаад бодлогын уламжлал болон бодит байдлаа харгалзан нийтлэг хувь заяаны агуулгыг доор дурдсан хэдэн талаар тоймлон дүгнэж байна.

1. Нийтлэг хувь заяа нь ашиг сонирхолын хамтын нэгдэл байж, үүнд эдийн засаг, аюулгүй байдал, нийгэм соёлын хамтын нийгэмлэгийг хамруулна

Үндэсний ашиг сонирхол давамгайлж буй өдгөөгийн олон улсын харилцаанд, ашиг сонирхолын хамтын нийгэмлэг үгүй л бол нийтлэг хувь заяа үүсч чадахгүй. Ашиг сонирхолын хамтын нийгэмлэг нь эдийн засаг, аюулгүй байдал, хүмүүнлэгийн салбарт нийтлэг илэрдэг. Эдийн засгийн харилцан хамаарлын талаар дээр нэгэнт өгүүлсэн. Нийгэм хүмүүнлэгийн хувьд, мэдээлэл технологийн дэвшил болон тээврийн шинэчлэл нь “олон улсын иргэний нийгэм” гэсэн шинэ нэр томъёог бүдгэрүүлсэн байна. Аюулгүй байдлын хувьд, их гүрнүүд тус бүрдээ их хэмжээгээр хөнөөлт зэвсэг эзэмшиж байгаа нь бие биеэ

³ 习近平主席在博鳌亚洲论坛2015年年会上的主旨演讲（全文）-新华网
http://www.xinhuanet.com/politics/2015-03/29/c_127632707.htm

бүрмөсөн устгах чадвартай болжээ. Дэлхийн улс орнуудын аюулгүй байдлын харилцан хамаарал улам ихэсч, аль нэг улсын түгшүүрт байдал нь бусад улсад шууд буюу шууд бусаар нөлөөлж болзошгүй болжээ. Уламжлалт бус аюулгүй байдлын салбарт байдал бүр ч илүү төвөгтэй байна.

***2. Нийтлэг хувь заяа нь үнэт зүйлсийн шинэ
ойлголт байж, үнэт зүйлсийн хамтын нэгдэл
байгуулахыг зорьсон явдал мөн***

Хэдийгээр өнөөгийн дэлхий ертөнц нягт харилцаатай, ашиг сонирхолын уялдаатай байгаа ч улс орнуудын үзэл баримтлалын мөргөлдөөн, үнэт зүйлсийн зөрчилдөөн үүсч, зарим талаараа Хүйтэн дайны сэтгэхүйд баригдсаар байна. Хятад болон хөрш орнуудын үл итгэлцэл заримдаа ихэсдэг ба энэ нь голчлон Хятадтай түүхэн эсхүл нутаг дэвсгэрийн маргаантай улс оронд үүсдэг. Улс орнуудын ашиг сонирхолын харилцан хамаарал улам бүр их болж байгаа өнөөгийн нөхцөлд улс орон нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлсийг хэрхэн буй болгох, үүнд тулгуурлан улс орон хоорондын нийтлэг ашиг сонирхолыг нэмэгдүүлж, улмаар хамтын хөгжилд хүрэх нь олон улсын нийгэмлэгийн тулгамдсан асуудлын нэг юм. Нийтлэг хувь заяа хэмээх үзэл баримтлал нь адил бус улс төрийн тогтолцоо, үзэл суртал, соёл, соёл иргэншлийн ялгаагаас хэтийдсэн ойлголт болж, тэмцэл, зөрөлдөөн, явцуурхал гэхээсээ илүүтэйгээр хамтын ажиллагаа, уялдаа холбоог эрмэлзсэн даяаршлын үйл явцад нааштай нөлөөлж болохуйц нийтлэг үнэт зүйлсийг төлөвшүүлэн буй болгох гэсэн сайн сайхны төлөөх санаачилга юм. Нийтлэг хувь заяаны үзэл баримтлал нь дэлхийн олон талт байдал болон ялгаат байдлыг хамтад нь онцолж, харилцан хүндэтгэх, ардчилал зөвшилцлийн зарчмын дагуу, санаачлагч орны үзэл баримтлалыг илэрхийлж байгаа хэрэг юм. Үүнд харилцан хүндэтгэх зарчим нь улс орнуудын бүрэн эрх, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, сонгосон хөгжлийн замыг нь хүндэтгэхийг хэлнэ. Ардчилал зөвшилцлийн зарчим гэдэг нь “улс орнууд бүрэн эрхийн хүрэн дэх асуудлаа

өөрсдөө шийдэх, харин дэлхий нийтийн асуудлыг бол улс орнуудын засгийн газар, ард түмэн хоорондоо зөвшилцөн байж шийдэх, чингэхдээ зарчмаа олон улсын нийгэмлэгт заавал журамласан байх”-ыг хэлнэ.⁴ Хятадын үзэл баримтлал гэдэг нь “үл хүссэнийг нь өрөөлд бүү тулга”⁵ юм. Өөрөөр хэлбэл, Хятад нь өөрийн ашиг сонирхолыг зэрэгцээ хөршүүдийнхээ зүй ёсны ашиг сонирхолыг харгалзан бусад орон лугаа хамтын хөгжлийг ахиулахыг хэлнэ.

3. Нийтлэг хувь заяаны хамтын нийгэмлэгийн үзэл баримтлалд мөн хариуцлагын ухамсар багтдаг

Улс хоорондын харилцан хамаарал урьд өмнө байгаагүй түвшинд хүрсэн нь олон улсын харилцаан дахь харилцан шүтэлцээг улам тод болголоо. Ийнхүү өөрийн улс орны ирээдүйн сайн сайхны үүднээс, энэхүү хамтын нэгдэлд өөрийн гэсэн тодорхой үүрэг хариуцлага хүлээсэн байх хэрэгтэй. Хятадын өнөөгийн хөгжил нь дэлхийн улс орнуудын харилцан шүтэлцээтэй даяаршлаас ихээхэн хамааралтай байхын зэрэгцээ амжилт олохын хэрээр дэлхийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж байна. Одоогийн байдлаар, Хятад нь 130 гаруй орны хамгийн том худалдааны түнш бөгөөд дэлхийн хамгийн том худалдаалагч орон, хөрөнгө оруулалтын урсгалаар дэлхийд эхний гуравт орох бөгөөд хамгийн их хөрөнгө оруулалт татдаг орны нэг, хамгийн том байгалийн баялгийн импортлогч зах зээл юм. Азийн эдийн засгийн өсөлтөд Хятадын оруулсан хувь нэмэр 50 хувийг, дэлхийн эдийн засгийн өсөлтөд оруулсан хувь нэмэр 30 хувийг давж, дэлхийн эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр болов.

Хятадын хүчин чадал өсч нэмэгдэхийн дагуу, түүний олон улс дахь үүрэг хариуцлага дээшилсээр байна. Тухайлбал, 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш, Хятад нь ОУВС-г

⁴ 顺应时代前进潮流 促进世界和平发展——习近平在莫斯科国际关系学院的演讲【2】——理论-人民网<http://theory.people.com.cn/n/2013/0325/c40531-20902911-2.html>

⁵ 邱耕田：《“命运共同体”：一种新的国际观》，《学习时报》2015年6月8日。

санхүүжүүлж бэрхшээлд тулгарсан улс орнуудад тусламж үзүүлсэн төдийгүй, өөрийн тогтвортой өсөлт нь шинээр хөгжиж буй орнуудтай хамт дэлхийн эдийн засгийн сэргэлтийн чухал хүчин болов. Хятадын талаас дэвшүүлсэн “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд байгуулсан Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, хөрш зэргэлдээ орнууд хоорондын дэд бүтцийн төсөл, “Торгоны зам сан”, тэрчлэн 2019 оны 3 дугаар сарын эцэс хүртлэх хугацаанд Хятадын засгийн газраас 125 орон болон 29 олон улсын байгууллагатай үзэглэсэн “Нэг бүс, нэг зам”-ын хүрээн дэх нийт 173 хамтын ажиллагааны баримт бичиг⁶ зэрэг нь тус санаачилгын үйл явц эрчимтэй өрнөж, Хятадын дэлхийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг хариуцлагын идэвхижлийг илэрхийлж байна. Хятад нь НҮБ-ын үндсэн чиглэл, зарчмын үйл ажиллагаанд идэвхитэй оролцохын зэрэгцээ НҮБ-ын гишүүн орнуудаас татах хураамжийн хоёрдугаар том эх үүсвэр юм.

Аюулгүй байдлын хувьд, Хятад нь Иран, Хойд Солонгосын цөмийн асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хариуцлагатай байр суури ил тод харуулаад зогсохгүй, уламжлалт бус аюулгүй байдлын салбарт, тухайлбал Африкийн Эбола вирусын эсрэг тэмцэх, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, гамшигтай тэмцэх болон хүмүүнлэгийн тусламжид хөгжиж буй том гүрний гүйцэтгэвээс зохих үүрэг хариуцлагаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайван, хөгжлийн үйлсэд хувь нэмрээ оруулсаар ирэв. Иймийн учир, Ши Жиньпин даргын дэвшүүлсэн хөрш орнуудын нийтлэг хувь заяа, Ази-Номхон далайн нийтлэг хувь заяа, хүн төрөлхтөний нийтлэг хувь заяаны үзэл баримтлал нь дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдөж, “хүн төрөлхтний нийтлэг хувь заяа”, “Нэг бүс, нэг зам” санаачилга нь НҮБ, G20, БРИКС, ШХАБ-ын холбогдол бүхий албан бичигт тусгагдсан байна.

⁶ 《共建“一带一路”倡议：进展共建“一带一路”倡议：进展、贡献与展望》[R/OL]. 中国政府网, http://www.gov.cn/xinwen/2019-04/22/content_5385144.htm, 2019-04-22.

Гурав. Хятад Монголын шинэлэг харилцааны арга замын тухай

Хөгжил, аюулгүй байдлын аль алины хувьд хөрш зэргэлдээ орнууд нь Хятадын сэргэн мандалтын стратегийн дэмжлэг бүсүүд юм. Стратегийн дэмжлэг бүс учир харилцаагаа сайжруулж, хамтдаа хожсон байх ёстой. БНХАУ байгуулагдсаны дараахан Хятад нь зарим хөршүүдтэйгээ хамтран, энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмыг дэвшүүлж, шинэчлэл нээлтийн дараа сайн хөрш, сайн түнш хөршийн бодлого хэрэгжүүлж, биелүүлсэний хойно найрсаг хөрш, баян хөрш, амгалан хөршийн стратеги хэрэгжүүлсэн бол өдгөө хөрш орнуудын нийтлэг хувь заяаны үзэл баримтлал дэвшүүлж, хөрш орнуудын харилцаанд шинэ ойлголт, уур амьсгалыг буй болгов. “Европын холбоо” нь европын нүүрс гангийн холбооноос эхлэлтэй бөгөөд түүний төлөвшилт нь тогтолцоонд тулгуурласан бол хөрш орнуудын нийтлэг хувь заяаны үзэл баримтлал нь шинэ ойлголтын хувьд өөрийн гэсэн онцлогтой юм. Хөрш орнуудын нийтлэг хувь заяа нь хамтдаа оршин, хамтын эрх ашгийг тусгасан нарийн төвөгтэй харилцаа бөгөөд түүний төлөвшилт байгуулалт нь нийтлэг эрх ашигт суурилсан хамтын ажиллагаанд тулгуурласан байна. Ийнхүү хөрш орнуудын нийтлэг хувь заяа нь наад захдаа хөгжлийн үр дүнгээ хуваалцах, хамтын аюулгүй байдлыг хангах, иргэд хооронд эвсэг харилцах гэсэн онцлог шинжийг бүрдүүлсэн байх ёстой. Энэ явцад Хятадын тал хөрөнгө, хүчний оруулалтаа нэмэгдүүлэх нь чухлаас гадна, хөрш орнуудын ойлголцол, хамтын ажиллагаа, хүчин чармайлт дутагдаж болшгүй юм.⁷

Хятад Монгол хоёр харилцан нэгэндээ хамгийн урт хилийн шугамтай, хөгжлийн болон аюулгүй байдлын олон нэгдмэл ашиг сонирхолтой ойр хөршүүд юм. Нэг талаар, Хятад нь тогтвортой стратегийн аюулгүй байдлын орон зай, ойр дөхөм эрчим хүч байгалийн баялгийн нийлүүлэгч, хурдан шуурхай дамжин өнгөрөх тээврийн коридор, найдвартай олон улсын болон бүс нутгийн

⁷ 中国与周边关系：命运共同体的逻辑（3）_人民时政_人民论坛网
http://politics.rmlt.com.cn/2014/0217/231209_3.shtml

асуудлаарх түнштэй байх шаардлагатай. Нөгөө талаар, Монголын хөгжил нь хоёр их хөршөөс, ялангуяа Хятадаас ихээхэн хамааралтай бөгөөд Хятадын тогтвортой байдал нь Монголын хөгжил дэвшилд ач тустай билээ. Хятадын дэвшүүлсэн “Нэг бүс, нэг зам” санаачилга хийгээд түүний хүрээн дэх гурван улсын бодлогын уялдаа болох “Хятад–Монгол–Оросын эдийн засгийн коридор” нь Монголын хөгжилд урьд өмнө байгаагүй боломжийг олгож байна. Тухайлбал өнөөгийн эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дэд бүтцээ хөгжүүлэх, эдийн засгаа солонгоруулах, найдвартай далайн гарцтай болох, бүс нутгийн эрчим хүчний сүлжээг үүсгэн өөрийн байр сууриа бататгах, бүс нутгийн эдийн засагт идэвхитэй оролцох, бүс нутгийн интеграцийг хэрэгжүүлэх зэрэг.

Хөрш орнуудын нийтлэг хувь заяа буюу шинэлэг харилцааг хэрхэн бий болгох талаар зарим судлаач: “Нэг, Хамтын хөгжлийг гол агуулгаа болгох. Хоёр, Харилцан итгэлцэл, хамтын ажиллагаагаар аюулгүй орчныг хамгаалах. Гурав, Нээлттэй хүлээцтэй механизм байгуулах. Дөрөв, Соёлын солилцоогоор үзэл бодлын зөвшилцөлд хүрэх. Тав, Хамтын зүтгэлээр сэтгэлгээний холбоосыг бэхжүүлэх” санал дэвшүүлжээ.⁸ Хятад Монголын харилцааны түүхэн уламжлал ба одоогийн байдал, “Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор” байгуулах үе шат зэргийг харгалзан, “амарханаас төвөгтөйд хүрэх” зарчмын дагуу Хятад Монголын шинэлэг харилцааг буй болгох талаар дараах арга хэмжээнүүд нь чухал юм.

***1. Өндөр дээд түвшний харилцан айлчлалын
давтамжийг хадгалж, улс төрийн
итгэлцлийг нэмэгдүүлэх***

Зарим талаараа Хятад ба АНУ, Хятад ба хөрш орнууд хоорондын улс төрийн итгэлцлийн алдагдал нь нийтлэг хувь заяа байгуулахад тулгардаг хамгийн том саад болдог тул улс төрийн

⁸ 刘振民：《坚持合作共赢携手打造亚洲命运共同体》，《国际问题研究》2014年第2期。

итгэлцлийг бий болгох нь маш том бөгөөд түвэгтэй системт ажил юм. Хятад Монголын харилцаанд газар нутгийн хийгээд улс төрийн шийдэгдээгүй асуудал байхгүй, харин ч иж бүрэн стратегийн түншлэлийг гүнзгийрүүлэх шатанд хоёр талын улс төрийн итгэлцэл түүхэн шинэ түвшинд хүрсэн байна. Гэсэн ч улс хоорондын ашиг сонирхолын ялгаа зэргээс улбаалан улс төрийн итгэлцэл хангалттай биш, ялангуяа улс төрийн эмзэг асуудалд нухацтай хандаж, харилцан хүндэтгэх, зөвшилцөх зарчмаар шийдэхгүй бол зарим үйл явдал эрх ашгийг хөндөж, хоёр талын харилцааны улс төрийн суурьд өө сэв суулгаж мэдэх талтай. Хөрш орнуудын нийтлэг хувь заяа байгуулахад худалдаа эдийн засгийн харилцаа нь материаллаг агуулгатай. Гэсэн ч улс төр, аюулгүй байдлын зорилт нь түүнээс хамааралтай бус байх ёстой. Улс төрийн итгэлцлийг нэмэгдүүлэх зорилгоор хоёр тал дээд хэмжээнд тодорхой зохицуулалт хийх хэрэгтэй. Практикаас үзэхэд, Хятад нь хэдийгээр худалдаа эдийн засгийн харилцааны хувьд ихэнх хөршүүдийнхээ хамгийн том худалдааны түнш болсон ч, энэхүү давуу тал нь улс төрийн итгэлцэл рүү улиран хувисахгүй байна. Улмаар улс төрийн итгэлцлийн хангалтгүй байдал нь худалдаа эдийн засгийн харилцаанд сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг. Хятад Монгол хоёр орны удирдагчид дээд түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалан, уулзалт, зөвшилцөл, тохиролцоонд суурилсан хоёр орны харилцааны зураглалыг байнга хийж, янз бүрийн түвшний механизм бүрдүүлэх шугамаар, түүний бодит агуулгыг баяжуулан, улс төрийн харилцааны эрүүл, тогтвортой хөгжлийг зохицуулан удирдсан байх шаардлагатай.

2. “Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор”-ийн томоохон төслүүдийг үе шаттай хэрэгжүүлэн, эдийн засгийг хөрш орнуудын нийтлэг хувь заяаны суурь болгох нь

Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа бол улс хоорондын харилцааны материаллаг суурь юм. Хятад Монгол хоёр аль алиан нь эдийн засгаа хөгжүүлэх, түүний бүтцийг өндөржүүлэх, ард иргэдээ чинээлэгжүүлэх үүрэгтэй. Хятад Монгол хоёр орны хамтын

ажиллагаанд хамтын хөгжил байхгүй л бол хөрш орнуудын нийтлэг хувь заяа байгуулах ажил амжилтад хүрэх боломжгүй юм. Ер нь эдийн засгийн хамтын нэгдэл байгуулахыг аюулгүй байдал, нийгэм соёл, үнэт зүйлсийн хамтын нэгдэл байгуулахтай харьцуулахад өмнөх нь объектив шинжтэй үр дүн нь илэрхий тул харьцангуй хялбар байдаг. Ийнхүү амархнаас төвөгтэйд хүрэх зарчмын дагуу түүнийг материаллаг суурь болгон хэрэгжүүлэх нь үйл явц, үр дүнгийн хувьд чухал юм. Өнөөгийн нөхцөлд, Монгол талын сонирхол нь юуны өмнө Хятадын хөгжлийг хөгжлийнхөө түлхэц болгоход ашиглах юм. Ийнхүү хоёр орны хувьд нэгэнт тохирсон бодлогын уялдаа болон “Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн дагуу томоохон төслүүдийн хэрэгжилтийн өмнөх шатны судалгааны болон зөвшилцлийн ажлыг эрчимжүүлж, түүнийг эртхэн эхлүүлэх нь хоёр орны шинэлэг харилцаа буй болоход таатай нөхцөл болж болох юм. Бүс нутгийн хувьд Хятад Монголын Чөлөөт худалдааны хэлэлцээрийн явцыг түргэсгэж, Монголыг Хятад, Япон, Өмнөд Солонгосын Зүүн Азийн бүс нутгийн интеграцид⁹ татан оролцуулах нь Зүүн хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааг ахиулах төдийгүй, бүс нутгийн хэмжээний том зохицуулалт хийх боломж нээгдэж, тэрчлэн бүс нутгийн нийтлэг хувь заяа байгуулах гарц болж болох юм.

Эдийн засгийн коридорын байгуулалт нь хоёр орны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны өндөржсөн хувилбар байж, зөвшилцөх, байгуулах, хуваалцах зарчмын дагуу энх тайван ч, нээлттэй, хүлээцтэй, харилцан суралцсан, харилцан ашигтай хамт хожих ойлголтод суурилан хоёр орны бодлогын уялдаа холбоог гүнзгийрүүлэх замаар харилцан шүтэлцээ бүхий шинэлэг харилцаанд хүрэх хэтийн төлөвийг харуулж байна.

Энэхүү явцад, Монголын талын амин чухал ашиг сонирхолыг гүйцэд харгалзах хэрэгтэй. Одоогийн байдлаас үзэхэд, хоёр орны худалдаа эдийн засгийн харилцааны гол салбар нь ашигт малтмал, дэд бүтэц, санхүүгийн хамтын ажиллагаа байна. Гэсэн

⁹ Хятад, Өмнөд Солонгосын ЧХХ 2014 оны 11 дүгээр сард байгуулагдав.

ч бэрхшээлтэй эмзэг салбар байсаар. Учир нь эдгээр салбарын дийлэнх нь Монголын стратегийн салбарууд байж, үндэсний хөгжил, аюулгүй байдалд шууд нөлөөлдөг. Нөгөөтэйгүүр, томоохон төслийн хэрэгжилт нь Монголын хөгжилд асар их жин эзэлдэг. Иймээс томоохон төслийн хэрэгжилт, дамжин өнгөрөх тээвэр, далайн гарцын нөхцөлийн талаар Монголын байр суурийг сайтар харгалзах нь үйл явц, үр дүнд нөлөөлөх чухал хүчин зүйл болно.

***3. Соёл хүмүүнлэгийн солилцоог эрчимжүүлж,
иргэдийн ойлголцлыг ахиулан, хоёр орны харилцааны
нийгмийн суурийг бэхжүүлэх нь***

Улс хоорондын харилцааны үндэс нь соёл хүмүүнлэгийн солилцоонд суурилсан иргэд хоорондын харилцаа, ойлголцол, хүлцэл, хүлээн зөвшөөрөлцсөн байдалд байдаг. 2014 онд Ши Жиньпин дарга Монгол Улсад төрийн айлчлал хийхдээ, тус салбарын хамтын ажиллагаанд анхаарал хандуулж, Хятадын талаас Монголд олгох энэ салбарын амлалт урьд өмнө байгаагүй түвшинд хүрэв.¹⁰ Тус хүрээнд хоёр орны хүмүүнлэгийн солилцооны хамтарсан комиссын анхдугаар уулзалт амжилттай зохион байгуулагдахын сацуу, сүүлийн жилүүдийн дээд өндөр түвшний айлчлалын хүрээнд хүмүүнлэгийн харилцаа чухал байр суурийг эзлэн, эрчимтэй өрнөж байна. Нөгөө талаар, засгийн газар, яам, агентлаг, орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага, иргэд аж ахуйн нэгж хоорондын соёл, урлаг, боловсрол, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шинжлэх ухаан технологи, аялал жуулчлал, спортын салбарын үр дүнтэй хамтын ажиллагаа өдөр ирэхүйеэ нэмэгдэж, ард иргэдийн ойлголцолд ахиц гаран, хоёр талын харилцааны нийгмийн суурь бэхжсээр байна.

Гэсэн ч хоёр улсын соёл хүмүүнлэгийн хамтын ажиллагаанд оршиж буй сул талыг илрүүлэн, түүнд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Үүнд:

¹⁰ 习近平主席访蒙发表演讲 彰显周边外交新境界_新闻中心_中国网
http://news.china.com.cn/world/2014-08/26/content_33338855.htm

1. Аялал жуулчллын хамтын ажиллагааг өргөн цар хүрээнд эрчимжүүлэх. 2018 онд Хятадын 140 сая хүн гадагш жуулчилсан нь энэ талаараа дэлхийд тэргүүлэх үзүүлэлт болжээ. Хятад сүүлийн хорь гаруй жилд Монголд ирэх гадаад жуулчдын гол орон байгаа ч тоо нь жилд 300 мянгад хүрэхгүй байна. Хятадын жуулчдыг татах талаар Монгол нь ойр хөршийн давуугаа ашиглаж чадахгүй байна. Иймд одоо байгаа хил дамнасан аялал жуулчлалын бүс, цайны зам, талын торгоны зам, нүүдлийн соёл зэрэг давуу талаа ашиглан, төсөл хөтөлбөр боловсруулах, Хятад жуулчдыг хэрхэн татах талаар хоёр талын хамтын ажиллагаа чухал байж, эдийн засаг, харилцан ойлголцлын үр ашигт хүрч болох юм. Нөгөө талаар Хятад нь Монголын жуулчдын хамгийн их зорилтот орон болохын хувьд, худалдан авалт, эмнэлэг эмчилгээ, суралцах, бизнесийн төрлийн жуулчдад боломжийн таатай нөхцөл хангах нь мөн ойлголцолд нааштайгаар нөлөөлөх орхигдуулж болшгүй чухал хүчин зүйл юм.
2. Хятад, Монголын соёлын төв, күнзийн сургууль, соёлын өвийг хамтран бүртгүүлэх, хятад хэлний сайн дурынхан зэргийг эрчимжүүлж, түүний соёлын ойлголцол, харилцан суралцахад гүйцэтгэх үүргийг өндөржүүлэх.
3. Боловсролын салбарын хамтын ажиллагааны чанар чансааг дээшлүүлэх. Хятадын засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, сургууль хоорондох хэлэлцээр болон хувийн шугамаар Хятадад суралцаж байгаа Монголын оюутан, сурагчдын тоо 10,000 гаруйд хүрснээр Хятад нь Монголын оюутан, сурагчдыг хамгийн олноор хүлээн авдаг орон болов. Эх сурвалжуудаас харахад, Хятад дахь Монгол оюутны сургалт, удирдлага, мэргэжлийн чиглэлд сул тал байна. Сургалт, удирдлагын хувьд, Монгол оюутныг хүлээн авдаг Хятадын их дээд сургуулиуд гадаад оюутанд хэт хүлээцтэй ханддагийн учир сургалт, удирдлагын

хяналт султай. Ноцтой хэрэг гаргахгүй л бол төгсгөх ба тодорхой хэмжээний төгсөгчид шаардлагын түвшинд хүрэхгүй байх асуудал оршиж байна. Иймд, хоёр талын холбогдох яам, агентлаг, сургуулиуд зохих арга хэмжээ авч удирдлагын хяналтыг чангатгах шаардлагатай. Мэргэжлийн чиглэлийн хувьд, дийлэнх нь нийгмийн ухааны салбарт суралцаж байгаа нь Монголын боловсон хүчний эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байна. Ийм учир Монголын нийгэм эдийн засгийн хөгжилд тулгам шаардагдах аж үйлдвэр, уул уурхай, мэдээлэл технологи, инженерийн чиглэлийн оюутны тоог нэмэгдүүлэх, мөн оюутан элсэлтийн явцад үүсэх залилан, наймаалцах үзэгдлийг таслан зогсоох шаардлагатай. Монголын хөгжил хийгээд хоёр орны найрсаг харилцаанд оюутан сургалтын гүйцэтгэх үүрэг нь тооноос илүү чанарт байх ёстой.

***4. Хятад Монголын хөрш орнуудын нийтлэг
хувь заяа буюу шинэлэг харилцаа байгуулах тухайд
хамтарсан судалгаа явуулах нь***

Хятад Монгол хоёр нь түүх, шашин, соёлын ойлголтын талаар тодорхой ялгаатай ч, уул усаар залгалдсан өнө мөнхийн хөршийн харилцаанд энэ талаарх олон нийтлэг хуримтлалтай юм. Энэ нь хөрш орнуудын нийтлэг хувь заяаны ойлголтод хүрэх чухал үнэт өв юм. Орчин үеийн эдийн засгийн даяаршил болон түүний чухал тодорхойлогч болох Хятадын хүчин чадлын өсөлт, “Нэг бүс, нэг зам” санаачилгын хэрэгжилтийн хэрээр Хятад Монголын хамтын ашиг сонирхол өсөн тэлж, Монголын хөгжил нь хөрш, түүний дотор Хятад лугаа харилцаанаас ихээхэн хамаарах хандлагатай болов. Нөгөө талаар Ши Жиньпин даргын дэвшүүлсэн хөрш орнуудын нийтлэг хувь заяаны үзэл баримтлал нь шинэлэг нэр томъёо, ойлголт, бодлого, боломж тул аль аль талаасаа түүнийг сайтар судалж, ойлгож, ашиглахыг хичээх хэрэгтэй. Одоогийн байдлаар Монгол судлал, Хятад судлалын хамтарсан судалгаа тодорхой түвшинд

явагдаж байна. Хятад Монгол хамтран соёлын өвөө бүртгүүлэх, Хятад, Орос, Монголын Think Tank холбоо, уламжлалт анагаах ухааны хамтарсан судалгааны ажил нэгэнт эхэлж, зохих үр дүнгээ өгч байна. Гэсэн ч эдгээр нь ихэвчлэн төрөлжсөн судалгаа тул Хятад Монголын харилцааны хэтийн төлөвийг шинэлэг байр суурь, чиг хандлагаар нарийвчлах талаар учир дутагдалтай. Ийнхүү хөрш орнуудын нийтлэг хувь заяаны үзэл баримтлалыг сайтар судалж ойлгох, үр өгөөжийг нь өөр өөрийн хөгжилд гүйцэд ашиглах үүднээс хамтарсан судалгааг аль болох эрт эхлүүлэх хэрэгтэй. Хоёр орны харилцаанд хөршүүдийн нийтлэг хувь заяаны үзэл баримтлалыг хэрхэн тусгах, дээр дурдсан нийтлэг үнэт өвийг суурь болгон хэрхэн ашиглах, олон улсын харилцааны онол практикыг хэрхэн баяжуулах, шинэ эриний хөрш орнуудын нийтлэг хувь заяаг хэрхэн байгуулах зэрэг нь хоёр талын холбогдол бүхий судлаач, эрдэм шинжилгээний болон Think Tank байгуулагуудын өмнө тулгараад байгаа асуудлын нэг боллоо. Үүнд Хятад нь санаачлагч том гүрний хувьд, хүлээцтэй, орчин үеийн дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байр сууринаас түүх, соёл, шашны асуудалд хандаж, хоёр орны эрдэм шинжилгээний институциудын хамтарсан судалгаанд түлхүү ач холбогдол өгч, бодлого ба санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь нааштай үр дүнд хүрэхийн эхлэл юм. Учир нь хил дамнасан түүх, соёл, шашны нийтлэг үнэт өвийг уялдуулсан хөршүүдийн нийтлэг хувь заяаны үзэл баримтлалаар удирдамж болгон орчин үеийн олон улсын харилцааны онол практикд суурилсан өндөр түвшний хамтарсан судалгаа нь үр дүнгийн хувьд, аль алины үзэл бодол, байр суурь, чиг хандлагыг хамруулснаараа хоёр талын шийдэл гаргагчдаас эгэл иргэдэд хүртэх ашиг тустай байж, амархан хүлээн зөвшөөрөгдөх ба хэрэгжүүлэхэд хялбар байх талтай.

***5. Зорилтот зөвшилцлийн механизмыг бий болгож,
хэрэгжилтийн үйл явцыг хурдасгах нь***

Нийтлэг зарчим, тогтолцоогүй нөхцөлд хөрш орнуудын нийтлэг хувь заяаны ойлголт, төлөвшилтөд олон бэрхшээлд тулгарч

болзошгүй. Иймд зорилтот механизмыг бий болгох нь ажлын үйл явцыг шуурхайлах, түүний үр өгөөжийг нэмэгдүүлж, хөршүүдийн нийтлэг хувь заяаны үзэл баримтлалын хэрэгжилтийн үр дүнд түлхэц болж болох юм. Одоогийн байдлаар, Хятад Монгол хоёр улс засгийн газрын түвшинд худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны комисс, уул уурхай ба дэд бүтэц, хүмүүнлэгийн солилцооны дэд комисс зэрэг механизмуудыг ажиллуулж байна. Орон нутгийн болон салбаруудын түвшинд мөн олон хамтын ажиллагааны механизмууд байна. “Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор” байгуулах тохиролцоонд хүрснээс гурван талт яриа хэлэлцээрийн механизмууд нэмэгдсээр байна. Гэхдээ эдгээр нь цаг үеийн хөгжлийн хурдыг дагаж амжихгүй нь бодит байдалд харагдаж байна. Ийнхүү хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хөршүүдийн нийтлэг хувь заяаг байгуулах үүднээс бодит хэрэгцээ шаардлагыг үндэслэн, харилцан хүндэтгэх, зөвшилцөх, байгуулах, хуваалцах, суралцах, цогц зарчмын дагуу хоёр талт болон Оросыг багтаасан гурван талт зорилтот яриа хэлэлцээрийн механизмыг бий болгох нь ажил хэргийн шуурхай хэрэгжилтэд дутагдаж болшгүй үүрэг гүйцэтгэх болно. Тэр нь яриа хэлэлцээрийн тавцан болохын зэрэгцээ ажил хэргийн тавцан байх хэрэгтэй. Улс хоорондын ямар ч төсөл хөтөлбөр, гэрээ хэлэлцээр, тохиролцоо хийгээд түүний хэрэгжилт нь төрөл бүрийн механизмд суурилдаг. Энэ утгаараа хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн, ажил хэрэгч механизмыг олон тоогоор буй болгох нь хоёр талын хамтын ажиллагааны зүй ёсны шаардлага юм. Тухайлбал, Хятад Монгол хоёр талын Соёлын сайд нарын, Боловсролын сайд нарын, их дээд сургуулийн захирлуудын, залуу манлайлагчдын, хотын дарга нарын, муж аймгийн дарга нарын зэрэг яриа хэлэлцээрийн механизмуудыг дурдаж болох юм.

Дүгнэлт

Хөршүүдийн нийтлэг хувь заяаны үзэл баримтлал бол Ши Жинпин даргын Хятадын дотоод гадаад орчны шинэ өөрчлөлтийг үндэслэн, хамтын ажиллагаа, хамтын хөгжлөөр бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг батлахын тулд дэвшүүлсэн олон улсын харилцаан дах шинэ ойлголт, шинэ боломж мөн. Түүнд эдийн засаг, аюулгүй байдал, нийгэм соёл, үнэт зүйлсийн хамтын нийгэмлэг болон хариуцлагын ухамсар зэрэг агуулгыг багтааж, төлөвшүүлэн байгуулахад, харилцан хүндэтгэх, ардчилал зөвшилцлийн зарчмыг баримтлан, Хятадын тал хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхээс гадна, хөрш орнуудын ойлголцол ба хамтын ажиллагаа, хамтын хүчин чармайлт дутагдаж болшгүй. Хятадын сэргэн мандалт нь зайлшгүй бүс нутгийн орнуудтай хөгжлөө хуваалцах, хамтаар дэвших үйл явцад биеллээ олно. Ийнхүү Хятадын хөгжлийн үр өгөөж юуны өмнө хөршүүдэд тусч, хүн төрөлхтний нийтлэг хувь заяаны их байгуулалт хөршүүдээс эхлэх учиртай. Энэхүү явцад, “Нэг бүс, нэг зам” санаачилга ба түүний хүрэн дэх “Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор” хөрш орнуудын нийтлэг хувь заяаны үзэл баримтлалын хэрэгжилтийн чухал тавцан юм.

Хятад Монгол хоёр нь хөгжил, аюулгүй байдлын хувьд маш олон хамтын ашиг сонирхолтой ойрын хөршүүд. Хятад Монголын хөрш орнуудын нийтлэг хувь заяа буюу шинэлэг харилцааг бий болгох нь хоёр орны хамтын ашиг сонирхолд нийцэхээр барахгүй бүс нутгийн нийтлэг ашиг сонирхолд нийцэж, тэрчлэн “Нэг бүс, нэг зам” санаачлагын хэрэгжилтэд чухал үлгэр жишээч үр нөлөөтэй.

Энэхүү харилцааг буй болгоход:

Өндөр дээд хэмжээний харилцан айлчлалын давтамжийг хадгалж, хоёр орны улс төрийн итгэлцлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, хоёр талын харилцааны замын зураглал хийх.

“Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор”-т хамрагдсан

Хөрш орнуудын нийтлэг хувь заяаны үзэл баримтлал хийгээд
Хятад, Монголын харилцаа

төслүүдийн хэрэгжилтийн өмнөх шатны судалгааны ба зөвшилцлийн механизмыг эрчимжүүлж, томоохон төслийг үе шаттай хэрэгжүүлэн, эдийн засгаар хөрш орнуудын нийтлэг хувь заяаны материаллаг агуулга болгох;

Соёл хүмүүнлэгийн солилцоог эрчимжүүлж, иргэд хоорондын харилцаа ойлголцлыг ахиулан, хоёр орны харилцааны нийгмийн суурийг бэхжүүлэх. Үүнд хоёр талын аялал жуулчлал, соёлын брэнд, оюутан сургалтын талаар онц анхаарал хандуулан, олон талт үр өгөөжийг нь нэмэгдүүлэх;

Хятад Монголын хөрш орнуудын нийтлэг хувь заяа буюу шинэлэг харилцааг төлөвшүүлэн байгуулах тухай хамтарсан судалгаа явуулах;

Зорилтот яриа хэлэлцээний механизмыг буй болгож, ажилч хэрэгч хэрэгжилтээр үзэл баримтлалын агуулгыг баяжуулах хэрэгтэй байна.

Peripheral community of shared future and Sino-Mongolian relationship

Khugjilt Borjigon

Associate Professor

Center for Mongolia Studies, Inner Mongolian University

Huhhot, PRC

E-mail: hugjilt_@126.com

Abstract: *The rise of any big country requires a peripheral supporting belt. The rise of China must be realized in sharing development and common progress with the regional countries. The characteristics of the community of shared future for mankind includes: sharing development achievements, achieving cooperation security, and people living in harmony. Building this community requires China to increase investment, and it requires the understanding and cooperation of neighboring countries. It also requires both sides to work hard and operate together. The construction of a Sino-Mongolian community of shared future or a new type of relationship needs to be promoted from the aspects of political mutual trust, economic and trade cooperation, humanities exchange, construction of discourse power and mechanism for further cooperation.*

Key words: *Peripheral community of shared future, new type of Sino-Mongolian relationship, path*

Ашигласан материал

1. 林利民：《中国对外战略：新问题、新任务、新思路》，《现代国际关系》2010年第11期。
2. 习近平主席在博鳌亚洲论坛2015年年会上的主旨演讲（全文）-新华网http://www.xinhuanet.com/politics/2015-03/29/c_127632707.htm。
3. 顺应时代前进潮流 促进世界和平发展——习近平在莫斯科国际关系学院的演讲——理论-人民网<http://theory.people.com.cn/n/2013/0325/c40531-20902911-2.html>。
4. 邱耕田：《“命运共同体”：一种新的国际观》，《学习时报》2015年6月8日。
5. 《共建“一带一路”倡议：进展共建“一带一路”倡议：进展、贡献与展望》[R/OL]. 中国政府网, http://www.gov.cn/xinwen/2019-04/22/content_5385144.htm, 2019-04-22.
6. 中国与周边关系：命运共同体的逻辑（3）_人民时政_人民论坛网, http://politics.rmlt.com.cn/2014/0217/231209_3.shtml。
7. 刘振民：《坚持合作共赢携手打造亚洲命运共同体》，《国际问题研究》2014年第2期。
8. 习近平主席访蒙发表演讲 彰显周边外交新境界_新闻中心_中国网, http://news.china.com.cn/world/2014-08/26/content_33338855.htm。